



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2018 оны 10 сарын 30 өдөр

Дугаар 500

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө олж авах
зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8 дахь хэсэг, “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 3.3, 3.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Биеийн тамир, спортын газрын албан ажлын хэрэгцээнд зориулан 1 ширхэг бага оврын автобусыг 30,000,000.00 (гучин сая) төгрөгт багтаан өөрийн хөрөнгийн эх үүсвэрээр олж авахыг зөвшөөрч, худалдан авах автобусны техникийн үзүүлэлт, үнийн дээд хязгаарыг хавсралтаар тогтоосугай.

2. Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Баярсайхан, Биеийн тамир, спортын газрын дарга Ц.Шаравжамц нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Үндсэн хөрөнгө худалдан авах ажлыг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Энэ тогтоолын биелэлтийг 2018 оны 4 дүгээр улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГА



Ц.НЯМ-ОСОР

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

Б. ГАВАА

0002395

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2018 оны 10 дугаар сарын 30 ны өдрийн
...500... дугаар тогтоолын хавсралт

Биеийн тамир, спортын газрын худалдан авах автомашины
техникийн үзүүлэлт, үнийн дээд хязгаар

Д/д	Автобусны техникийн үзүүлэлт, нөхцөл	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Худалдан авах үнийн дээд хязгаар
				(төгрөг)
1	Суудлын тоо 10 хүртэл, хөдөлгүүрийн багтаамж 3001 cc хүртэл, Гадаад улсад ашиглагдаж байгаад Монгол Улсад импортоор орж ирсэн бол тээврийн хэрэгслийн гэрчилгээ аваагүй байгаа автобус.	ш	1	30,000,000.00
Нийт дүн				30,000,000.00
				(гучин сая)